

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бүрэгхангай сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** БУА-2022/34/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Булган аймаг 2022 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр Утас: 70342580 Цахим хаяг: <a href="mailto:Ankhubayard@audit.gov.mn">Ankhubayard@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: <a href="mailto:Enkhtsoodolj@audit.gov.mn">Enkhtsoodolj@audit.gov.mn</a></p> <p>Аудитор: З.Ганбаатар Утас: 70342495 Цахим хаяг: <a href="mailto:ganbaatarz@audit.gov.mn">ganbaatarz@audit.gov.mn</a></p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1. Аудитын санал дүгнэлт .....	<b>Error! Bookmark not defined.</b>
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	<b>Error! Bookmark not defined.</b>
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	10
3.4 Материаллаг байдал .....	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал .....	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт .....	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	14

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БУЛГАН АЙМГИЙН  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс: 7034-3259  
E-mail: bulgan@audit.gov.mn

№ 73

танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

БҮРЭГХАНГАЙ СУМЫН СОЁЛЫН  
ТӨВИЙН ЭРХЛЭГЧ Д.БАТ-ӨЛЗИЙ  
ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1; 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бүрэгхангай сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бүрэгхангай сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

D:/bichighereg/2022A4toot

006020112

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

#### САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	7,564,962.00	100,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	7,564,962.00	100,000.00
354	Хангамжийн материал	7,564,962.00	100,000.00
35410	Бичиг хэргийн материал	91,200.00	-
35420	Аж ахуйн материал	7,040,762.00	-
35470	Бусад хангамжийн материал	433,000.00	100,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	203,419,462.62	192,586,625.17
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	203,419,462.62	192,586,625.17
392	Биет хөрөнгө	201,419,462.62	189,774,125.14
39201	Барилга, байгууламж, орон сууц	195,896,553.63	195,896,553.63
39202	Хуримтлагдсан элэгдэл	(26,511,845.62)	40,344,112.90)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	17,682,092.37	22,432,701.37
39206	Хуримтлагдсан элэгдэл	(3,256,297.86)	(5,600,491.53)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	10,155,031.40	11,132,842.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	(5,982,436.30)	(7,179,732.83)
39217	Ном	13,436,365.00	13,436,365.00
393	Биет бус хөрөнгө	2,000,000.00	2,812,500.03
39301	Программ хангамж	-	1,000,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(187,499.97)
39303	Бусад биет бус хөрөнгө	2,000,000.00	2,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	210,984,424.62	192,686,625.17
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	138,192,698.32	119,894,898.87
51	Засгийн газрын хувь оролцоо	138,192,698.32	119,894,898.87
512	Хуримтлагдсан үр дүн	49,502,973.04	31,205,173.59
51210	Өмнөх үеийн үр дүн	49,502,973.04	49,502,973.04
51220	Тайлант үеийн үр дүн	-	(18,297,799.45)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	88,689,725.28	88,689,725.28
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	138,192,698.32	119,894,898.87

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

#### САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	172,070,200.00	133,732,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,003,300.00	6,945,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,003,300.00	6,945,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,003,300.00	6,945,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	120,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	7,003,300.00	6,825,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	165,066,900.00	126,787,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	68,360,400.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	68,360,400.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	800,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	800,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	96,706,500.00	125,987,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	96,706,500.00	125,987,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	112,016,240.60	152,030,199.45

**Бүрэгхангай сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

21	УРСГАЛ ЗАРДАЛ	112,016,240.60	152,030,199.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	110,669,600.60	120,551,783.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	50,084,783.00	49,128,410.00
210101	Үндсэн цалин	39,560,420.00	38,824,227.00
210102	Нэмэгдэл	4,379,768.00	-
210105	Гэрээт ажлын хөлс	6,144,595.00	10,304,183.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,425,300.00	6,782,067.61
210201	Тэтгэврийн даатгал	4,369,300.00	4,757,913.68
210202	Тэтгэмжийн даатгал	514,000.00	528,141.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	411,200.00	397,535.07
210204	Ажилгүйдлийн даатгал	102,800.00	99,589.42
210205	Эрүүл мэндийн даатгал	1,028,000.00	998,888.28
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,393,277.00	35,062,276.00
210301	Гэрэл, цахилгаан	177,668.00	214,716.00
210302	Түлш, халаалт	34,215,609.00	34,847,560.00
2104	Хангамж, бараа материалын зардал	325,900.00	7,100,792.00
210401	Бичиг хэрэг	59,660.00	151,200.00
210402	Тээвэр, шатахуун	111,740.00	187,230.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	82,500.00	75,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	57,000.00	54,500.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	15,000.00	6,632,862.00
2105	Нормативт зардал	-	45,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	45,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,410,600.00	890,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	40,000.00
210604	Урсгал засвар	2,410,600.00	850,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	56,000.00
210702	Дотоод албан томилолт	-	56,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,155,000.00	2,029,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,047,000.00	2,029,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	108,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,874,740.60	19,457,837.45
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	550,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	15,874,740.60	18,907,837.45
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,346,640.00	31,478,416.39
2132	Бусад урсгал шилжүүлэг	250,000.00	28,801,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	28,601,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	250,000.00	200,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,096,640.00	2,676,616.39
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,096,640.00	2,676,616.39
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	60,053,959.40	(18,297,799.45)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	60,053,959.40	(18,297,799.45)

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	72,791,726.30	88,689,725.28	31,205,173.59	434,144,891.95
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	95,616,502.48	354,276,452.78	(15,748,063.31)	434,144,891.95
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(3,763,458.23)	(3,763,458.23)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	95,616,502.48	354,276,452.78	(19,511,521.54)	30,381,433.72

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	96,706,500.00	126,907,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	120,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	120,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	120,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	120,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	96,706,500.00	126,787,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	800,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	800,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	96,706,500.00	125,987,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	96,706,500.00	125,987,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	96,706,500.00	125,657,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	96,706,500.00	125,657,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	95,359,860.00	94,178,983.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	50,084,783.00	49,128,410.00
210101	Үндсэн цалин	39,560,420.00	37,738,681.00
210102	Нэмэгдэл	4,379,768.00	-
210105	Гэрээт ажлын хөлс	6,144,595.00	11,389,729.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,425,300.00	6,782,067.61
210201	Тэтгэврийн даатгал	4,369,300.00	4,757,913.64
210202	Тэтгэмжийн даатгал	514,000.00	528,141.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	411,200.00	397,535.28
210204	Ажилгүйдлийн даатгал	102,800.00	212,724.50
210205	Эрүүл мэндийн даатгал	1,028,000.00	885,752.52
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,393,277.00	35,062,276.00
210301	Гэрэл, цахилгаан	173,277.00	214,716.00
210302	Түлш, халаалт	34,220,000.00	34,847,560.00
2104	Хангамж, бараа материалын зардал	319,900.00	322,230.00
210401	Бичиг хэрэг	59,660.00	60,000.00
210402	Тээвэр, шатахуун	111,740.00	98,030.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	82,500.00	75,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	89,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	66,000.00	-
2105	Нормативт зардал	45,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	45,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,386,600.00	930,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	550,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	87,000.00	80,000.00
210604	Урсгал засвар	2,299,600.00	300,000.00
2107	Томилот, зочны зардал	-	56,000.00
210702	Дотоод албан томилот	-	56,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,705,000.00	1,898,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,597,000.00	1,898,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	108,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,346,640.00	31,478,416.39

**Бүрэгхангай сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2132	Бусад урсгал шилжүүлэг	250,000.00	28,801,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	28,601,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	250,000.00	200,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,096,640.00	2,676,616.39
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,096,640.00	2,676,616.39
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)		1,250,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	1,250,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	1,250,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	1,250,000.00
222001	Тоног төхөөрөмж	-	250,000.00
223001	Бусад хөрөнгө	-	1,000,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(1,250,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	126486400.00	123430783.61
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	126486400.00	122430783.61
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	97684600.00	93628983.61
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	51832800.00	49128410.00
210101	Үндсэн цалин	40210100.00	37738681.00
210105	Гэрээт ажлын хөлс	11622700.00	11389729.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	6997400.00	6782067.61
210201	Тэтгэврийн даатгал	4924000.00	4757913.64
210202	Тэтгэмжийн даатгал	518300.00	528141.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	414700.00	397535.28
210204	Ажилгүйдлийн даатгал	103700.00	212724.50
210205	Эрүүл мэндийн даатгал	1036700.00	885752.52
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	35191400.00	35062276.00
210301	Гэрэл, цахилгаан	343600.00	214716.00
210302	Түлш, халаалт	34847800.00	34847560.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	325000.00	322230.00
210402	Тээвэр, шатахуун	100000.00	98030.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	90,000.00	89,200.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	58,000.00	56,000.00
210702	Дотоод албан томилолт	58,000.00	56,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,900,000.00	1,898,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,900,000.00	1,898,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,000,000.00	-
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	1,000,000.00
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	1,000,000.00
223001	Бусад хөрөнгө	-	1,000,000.00
<b>13</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	126,257,400.00	126,107,400.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	126,257,400.00	125,987,400.00
132001	Орон нутгийн төсвөөс	126,257,400.00	125,987,400.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	-	120,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	120,000.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

### НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	/ төгрөгөөр /
			Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>800,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	<b>550,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	550,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	550,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	550,000.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>250,000.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	-	250,000.00
222001	Тоног төхөөрөмж	-	250,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>800,000.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	<b>800,000.00</b>
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	800,000.00

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Бүрэгхангай сумын соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд санхүүгийн тайлан, бүртгэлд гарсан алдаа зөрчилтэй, холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аудитор З.Ганбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Бүрэгхангай сумын соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Бүрэгхангай сумын соёлын төв нь “Хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрх, чиг үүргийг хэрэгжүүлж, сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх зүй зохистой тодорхойлон, түүнийг хэрэгжүүлэхэд иргэдийн бүтээлч санаачилга, идэвхтэй шууд оролцоог нэмэгдүүлэн, тэдний язгуур эрх ашгийг дээдлэн нутгийн өөрөө удирдлагын чадавхыг дээшлүүлэх” гэсэн эрхэм зорилгын хүрээн дотоод хяналт шалгалтыг 9 ажлын төлөвлөж хэрэгжүүлсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил

гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Бүрэгхангай сумын соёлын төвийн бүтэц орон тоонд дотоод аудит байхгүй бөгөөд дээд шатны төсөв захирагчийн санхүүгийн хяналт, дотоод аудитын хэлтэс 2021 онд төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бүрэгхангай сумын соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 126,814.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 1,268.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 887.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Бүрэгхангай сумын соёлын төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 18,297.8 буюу 9 хувиар буурсан байна байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/Мян.төг /		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урьдчилж гарсан зардал			
Авлага			
Бараа материал	7,564.9	100.0	-7,465.0
Үндсэн хөрөнгө	203,419.5	192,586.6	-10,832.8
Нийт хөрөнгө	0	0	
Өр төлбөр	0	0	
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/			
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	210,984.4	192,686.6	18,297.8

**Авлага:** Тайлант онд 0 төгрөгийн авлага

**Бараа материал:** Бараа материалын дансны үлдэгдэл 100.0 мянган төгрөг болж 7,465.0 мянган төгрөгөөр буурсан нь 4,244.1 мянган төгрөгийн бараа материалыг байгууллагын даргын 2021 оны 12 сарын 23-ны өдрийн А/09 тоот тушаалаар акталсан. Бичиг хэрэг-91.2, бусад хангамжийн материал-433.0, аж ахуйн материал-2,796.7 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалжээ.

**Үндсэн хөрөнгө:** Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 192,586.6 мянган төгрөг болж 10,832.8 мянган төгрөгөөр буурсан нь 1,346.6 төгрөгийн үндсэн хөрөнгийг байгууллагын даргын 2021 оны 12 сарын 23-ны өдрийн А/09 тоот тушаалаар акталсан байна. Тайлант хугацааны элэгдэл 18,907.8 нэмэгдсэн байна. Үндсэн хөрөнгийн данс нь хөрөнгө оруулалтаар 250.0 мянган төгрөг, урсгал төсвийн худалдан авалтаар 1,000.0, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 6,825.0, мянган төгрөгийн 8,075.0 хөрөнгөөр нэмэгдсэн байна.

**Өр төлбөр:** Тайлант онд өр төлбөрийн үлдэгдэлгүй байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 126,486.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71702 хөтөлбөрийн 80101, 80214 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 126,486.4 мянган төгрөгийн төсөв баталснаас 125,986.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 500.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 125,987.4, үндсэн үйл ажиллагаанаас 120.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 123,430.8 мянган төгрөгийг зарцуулж 2,676.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

“Ярилцъя шийдье” арга хэмжээний хүрээнд нийгмийн хариуцлагын гэрээний хүрээнд 800.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс байгууллагын интернэтийн асуудлыг шийдэж гэр интернэтийг 250.0 төгрөгийг зарцуулж, байгууллагын мэдээллийн самбарууд, гадна, дотно өрөө тасалгааны хаяг, ханын хулдаасан хэвлэлийг сольж шинэчлэх ажилд 550.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй онцолсон бусад асуудал буюу Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой дараах асуудлууд байна. Үүнд:

- Тус байгууллага 2021 оны батлагдсан төсөвт зардлын 2.1 хувиар буюу 2,676.6 мянган төгрөгийн хэмнэлт гаргаж ажилласан,
- Байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээний батлагдсан төсвөөс 128.9 мянган төгрөгийн хэмнэлтийг хийсэн байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тайлан үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

2021 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар “Шилэн дансны тухай”, Засгийн газрын 2014 оны 384 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай” журмын дагуу шилэн дансны цахим хуудсанд нийт 146 мэдээлэл оруулахаас хугацаа хоцроосон мэдээлэл байхгүй, хугацаанд нь оруулсан 146 мэдээг мэдээлж 1 мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Ажил олгогчийн НДШ-ийн зардлаас цалингийн зардалд 100.7 мянган төгрөгийг бүлэг хооронд зөвшөөрөлгүй шилжүүлэн зориулалт бус зарцуулсан нь Сангийн сайдын 2018 оны 6 сарын 8 өдрийн 134 дүгээр тушаалаар батлагдсан төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журмын 5.1.2 дахь заалт, сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 190 -р тушаалыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шилэн дансны цахим хуудсанд төсөв, өмч хөрөнгөтэй холбоотой тушаал шийдвэр, таван сая төгрөгөөс дээш орлогын мөнгөн гүйлгээг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5 дахь заалтад заасан мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь тухайн хуулийн 4.1.1.мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, 4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны аудитаар нийт 1 алдаа зөрчил илэрснээс 0 төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн байна. Зөвлөмжийн хэрэгжилтийг хугацаанд нь ирүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,798.6 мянган төгрөгийн 4 алдаа зөрчил илэрснээс, 1,250.0 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 447.9 мянган төгрөгийн 1 төлбөрийн актыг тогтоож, 100.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн байна.

### 4.1 Залруулсан алдаа

Худалдан авсан 1,250.0 мянган төгрөгийн хөрөнгийг шууд зардалд бичсэн нь НББ-ийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна." 15.2 дахь "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна." гэсэн заалтын дагуу залруулга хийсэн.

### 4.2 Төлбөрийн акт

Тайлант онд байгууллагын даргын 2021.11.01-ний өдрийн Б/05 тушаалаар өөрөө өөртөө тушаал гаргаж 11, 12 дугаар саруудад 447,972.0 төгрөгийн ур чадварын нэмэгдэл авсан нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 4 дэх "Энэ журмыг үндэслэн тухайн салбар, мэргэжлийн онцлогийг харгалзан төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг салбарын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн нь хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран тогтооно.", санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн байдал: Төлбөрийн акт тогтоосон.

### 4.3 Албан шаардлага

### 4.4 Зөвлөмж

**Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:**

#### 1. Зардлын данстай холбоотой асуудал

##### 1.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд ажил олгогчийн НДШ-ийн зардлаас цалингийн зардалд 100,652.0 төгрөгийг бүлэг хооронд зөвшөөрөлгүй шилжүүлэн зориулалт бус зарцуулсан байна.

Энэ нь Сангийн сайдын 2018 оны 6 сарын 8 өдрийн 134 дүгээр тушаалаар батлагдсан төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журмын 5.1.2 дахь заалт, сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 190 -р тушаалыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 190 -р тушаалыг бүрэн хэрэгжүүлэн ажиллах.

#### 2. Шилэн данстай холбоотой

##### 3.1 Илрүүлэлт:

тухай хуулийн хэрэгжилтийг тулган баталгаажуулахад хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5 дахь заалтад заасан мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь тухайн хуулийн 4.1.1.мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, 4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх гэсэн заалтуудыг бүрэн нийцэхгүй байна.

3.2 **Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны тухай хуулийн 4.1.1.мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, 4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

*/Мян.Төгрөгөөр/*

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Бүрэгхангай сумын Соёлын төв	4	1,798.6	1	1,250.0	1	447.9			2	100.7
	Нийт дүн	4	1,798.6	1	1,250.0	1	447.9			2	100.7